

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04 сарын 23 өдөр

Улаанбаатар хот

Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04 дугаар сарын 23-ны өдөр 15:00 цагаас 16:35 цагийн хооронд Шангри -Ла зочид буудлын 1-р давхрын Боллрүүм 2 хурлын танхимд хуралдаж, хурлын ирц, санал хураалт, асуултыг www.investmentexpo.mn вэбсайтаар хураав.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Балдангийн ЭНХТҮВШИН

Тооллогын комисс: З.Цэндсүрэн /Комиссын дарга/

Гишүүд: О.Золбоо

У.Номин

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 148

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 544,492,252 ширхэг

Хурлын ирц: 87 хувь буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин “Мандал Даатгал” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах шийдвэрийг 2022 оны 03 сарын 14-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаас шийдвэрлэсэн тухай мөн уг шийдвэрийн дагуу 2022 оны 03 сарын 17-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хүргүүлсэн тухай танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 2022 оны 03 сарын 18-ны өдөр, 2022 оны 04 сарын 04-ны өдрүүдэд тус тус мэдээлснийг танилцуулав.

Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2022 оны 03 сарын 18-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж, мөн www.investmetexpo.mn сайтад бүртгүүлсэн цахим хаяг руу цахим хэлбэрээр хурлын материалыг илгээж хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдрийг 2022 оны 04 сарын 04-ны өдрөөр тогтоосныг танилцуулав.

Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хураалтын аргачлал болон “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Ө.Ганзориг нээлтийн үг хэлснээр хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

2 дугаар асуудал: Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

3 дугаар асуудал: Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

4 дүгээр асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

5 дугаар асуудал: Компанийн ТУЗ-ийн хоёр ердийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж түүний оронд шинээр хоёр ердийн гишүүнийг сонгох;

6 дугаар асуудал: ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн 2021 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Батзул

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн 2021 оны санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны тайланг товч танилцуулав.

2021 оны орлого үр дүнгийн тайлан: Нийт хураамжийн орлогыг 35.6 тэрбум төгрөг, Хөрөнгө оруулалтын орлого 5.0 тэрбум төгрөг, Нөхөн төлбөрийн зардал 8.2 тэрбум төгрөг, Үйл ажиллагааны зардал 8.3 тэрбум төгрөг, Цэвэр ашгийг 5.6 тэрбум төгрөгт хүрсэн.

2021 оны санхүүгийн тайлан: Мөнгөн хөрөнгө 38.3 тэрбум төгрөг, Эздийн өмч 27.8 тэрбум төгрөг, Нийт хөрөнгө 58.7 тэрбум төгрөгт хүрсэн.

2021 оны ашигт ажиллагааны үзүүлэлт: Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 10% Эздийн өмчийн өгөөж (ROE) 22%, Төлбөрийн чадварын харьцаа 144% байсан.

Нийт нөхөн төлбөрийн 13,643 тохиолдол гарсан нь өмнөх оноос 0,2% өссөн, нийт 8,2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр төлсөн нь өмнөх оноос 4% өссөн, Эрүүл мэндийн даатгалын хувьд нөхөн төлбөрийн 8,551 тохиолдолд 2,4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр 2021 онд өгснийг танилцуулав.

Мандал Даатгал ХК-ны хувьд 2021 онд дараах онцлох үйл явдлууд болсныг танилцуулав. Үүнд:

1. Mandal app нэвтрүүлснээр зайнаас даатгалын үйлчилгээ авч болохоос гадна нөхөн төлбөрийн тохиолдол болсон бол зайнаас мэдээллээ оруулах, нөхөн төлбөрөө шийдвэрлүүлэх боломжтой болсон.
2. Мандал Даатгал ХК нь 2021 онд нийт 82,000 харилцагчтай болсон.
3. Mandal Risk School хүүхдэд эрсдэлийн боловсрол олгох контент болон сургалтыг нэвтрүүлж 20,000 хүүхэд хамрагдсан.
4. EDOCTOR эрүүл мэндийн вэбсайтыг ажлуулж 420 мянган хандалтыг авсан.
5. Приус, 4Х4, Седан зэрэг тээврийн хэрэгслийн даатгал болон Гүүмби Жүүмби хүүхдийн гэнэтийн ослын даатгалыг зах зээлд нэвтрүүлсэн.
6. Олон улсын AM BEST үнэлгээний байгууллагаас 2021 онд дахин BB+ үнэлгээ авсан.
7. Management Forum 2021 амжилттай зохион байгуулж Монголын ТОП 200 компаниудын удирдлагууд оролцсон.

“Мандал Даатгал” ХК-ны хувьцааны үзүүлэлтийг танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ны нийт гаргасан хувьцааны тоо 624,301,600 ширхэг, 2021 оны 12 сарын 31-ны өдрийн хаалтын ханш 96.92 төгрөг, Зах зээлийн үнэлгээ 60.5 тэрбум төгрөг, 2021 онд нийт 5.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн, 2021 оны өдрийн дундаж арилжаа 20.6 сая төгрөг байсныг танилцуулав.

Хувьцааны харьцаанууд: EPS 9.0, P/E харьцаа 10.8, P/B харьцаа 2.2,

2 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Батзул

Танилцуулгын гол агуулга:

“Мандал Даатгал” ХК нь “Грант Торнтон Аудит” ХХК-иар өмнөх 5 жилийн хугацаанд дараалан санхүүгийн тайландаа хөндлөнгийн аудит хийлгэсэн. Аудитын тухай хуульд аль нэг аудитын хуулийн этгээд нь нэг аж ахуйн нэгж, байгууллагад дараалсан 5 жилээс илүү хугацаанд аудитын үйлчилгээ үзүүлэхийг хориглоно гэж заасан байдаг. Мандал Даатгал ХК-ны ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдэлийн хороо аудитын байгууллагад сонгон шалгаруулалт явуулахдаа заавал олон улсын франчайз эрхтэй аудитын компани байх ёстой гэдэг шалгуур тавьсан. Тус шалгуурын хүрээнд сонгон шалгаруулалт явуулж “Пи Кэй Эф Монголиа Аудит” ХХК-ийг сонгосныг тайлбарлав.

“Мандал Даатгал” ХК-ны 2021 оны 11 сарын 16-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын 21/018 тоот тогтоолоор “Мандал Даатгал” ХК-ны 2021 оны Санхүүгийн тайланг батлах хөндлөнгийн аудитын компаниар “Пи Кэй Эф Монголий Аудит” компанийг сонгосон. “Пи Кэй Эф Монголиа Аудит” компани нь Олон улсын аудитын франчайз юм.

Дүгнэлтийн товч агуулга: Бидний дүгнэлтээр энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан холбогдох дүрэм журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн болохыг 2022 оны 03-р сарын 14-ний өдөр баталгаажуулсан байна.

3 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг

Танилцуулгын гол агуулга:

Мандал Даатгал ХК-ийн эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч та бүхэнд 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2021 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Мандал Даатгал ХК-ийн ТУЗ нь 2020 оны 12 сарын 24-ны өдрийн 20/014 тоот ТУЗ-ийн ээлжит хурлын тогтоолоор Мандал Даатгал ХК-ийн 2021 оны Бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны стратегийг баталсан. Бизнес төлөвлөгөө батлах үед 2021 оны Монголын улсын эдийн засаг тэр дундаа Даатгалын салбарын нөхцөл байдал тодорхойгүй байсан.

2021 он Даатгалын салбарын нөхцөл байдал тодорхойгүй байсан боловч Мандал Даатгал ХК 2021 онд нийт 35,6 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж, өмнөх оны мөн үеэс 7% өссөн, татварын дараах цэвэр ашиг 5.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23% өссөн.

Компанийн мөнгөн хөрөнгө 33,6 тэрбум төгрөгөөс 38,5 тэрбум төгрөг болж нэмэгдсэнээр хөрөнгө оруулалтын 5.0 тэрбум төгрөгт хүрсэн. Мөн нийт хөрөнгө 58.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 7% өссөн байна.

2021 онд Мандал Даатгал ХК нь цар тахалтай хүнд хэцүү үед даатгуулагчдаа нийт 8,2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр өгсөн байна.

Мандал Даатгал ХК нь 2020 онд олон улсын AM Best агентлагаас BB+ үнэлгээ авсан Монголын анхны компани болсон бол 2021 онд мөн AM Best агентлагаас дахин BB+ үнэлгээ авсан. Энэ үйл явдал нь Мандал Даатгал ХК нь хувьцаа эзэмшигч, харилцагчдын бидэнд итгэсэн итгэлийг дахин бататгаж, бидний ажлын үр дүнг дүгнэсэн явдал болсон. 2021 онд Мандал Даатгал ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан тул Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж ТУЗ-өөс дүгнэж байгааг танилцуулав.

Түүнчлэн 2021 оны 04 сарын 19-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас томилогдсон ТУЗ нь улирлын хурлаа цаг хугацаанд нь хийж, 2021 онд нийт 12 удаа ээлжит болон ээлжит бус хурал хуралдаж, компанийн бизнес төлөвлөгөө батлах, ногдол ашиг олгох зэрэг стратегийн 14 шийдвэрүүдийг гаргасан. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдэлийн хороо 6 удаа, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Цалин урамшуулал хороо 3 удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаанд хяналт тавин, ТУЗ-д зөвлөмж өгч ажиллаж байгааг онцлов.

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 02 сарын 18-ны өдрийн ээлжит хурлын 21/001 тоот шийдвэрээр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн

болохыг танилцуулав. Нэгж хувьцаанд 3 төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд нийт 1,872,904,800 төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөр тогтоосон. Ногдол ашгийг 2022 оны 05 дугаар сарын 31-ний дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах байдлаар хуваарилах болохыг мэдэгдэв.

5 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ТУЗ-ийн хоёр ердийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж түүний оронд шинээр хоёр ердийн гишүүнийг сонгох;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Танилцуулгын гол агуулга: “Мандал Даатгал” ХК-ийн одоогийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2021 оны 04 сарын 19-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 21/002 тоот тогтоолоор 3 жилийн хугацаатай сонгосон. ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Мөнхжаргал нь Голомт Файнэншл Групп ХХК-ийг төлөөлөн төлөөлөн удирдах зөвлөлд байдаг бөгөөд Голомт Файнэншл Групп ХХК-иас О.Мөнхжаргалын оронд Гансүх овогтой Дашдэндэвийг Мандал Даатгал ХК-ны төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэхийг санал болгосон.

Мандал Даатгал ХК-ны ТУЗ-ийн Гүйцэтгэх захирал байсан Б.Жавхлан нь ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажилдаг. ТУЗ нь Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байх нь компанийн засаглал болоод ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хувьд харилцан ойлголцоход зөв засаглал болно гэж үзсэн учир сонгосон. Б.Жавхлан нь Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн тул ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооноос Б.Жавхлангийн оронд Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байгаа Түмэннасан овогтой Батзулыг ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшүүлэхийг санал болгосон.

Тиймээс дараах хоёр хүнийг Мандал Даатгал ХК-ны ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшүүлж байгааг танилцуулав.

ТУЗ-ийн ердийн гишүүнд дараах 2 хүн нэр дэвшсэнийг танилцуулав: Үүнд

- | | |
|---------|---------------------------|
| а. Ноён | Гансүх овогтой Дашдэндэв |
| б. Ноён | Түмэннасан овогтой Батзул |

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нэр дэвшиж байгаа хоёр гишүүний анкетыг хувьцаа эзэмшигч нарт уншиж танилцуулав.

6 ДУГААР АСУУДАЛ:

Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

Танилцуулсан: “Мандал Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин

Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсвийг дараах бүтэцтэйгээр батлуулахаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Үүнд:

Компанийн ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн, хараат бус гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нийт 10 хүний 2022 оны жилийн цалин урамшуулал 154,0 сая төгрөг, Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн хурлын зардал 20,0 сая төгрөг, Бичиг хэрэг болон бусад зардал 6,0 сая төгрөг нийт 180,0 сая төгрөгийн төсвийг батлуулахаар танилцуулав.

Асуулт, Хариулт

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга асуулт хариулт эхэлснийг зарлаж тооллогын комиссын даргаас хувьцаа эзэмшигч нараас ирсэн асуултуудыг авав. Цахим хэлбэрээр хувьцаа эзэмшигчдээс санал авч байгаа бөгөөд, бүх хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах боломжгүй тул асуултуудыг агуулгын хувьд ижил болон олон давхацсан дөрвөн асуултуудад хариулахаар сонгосныг тайлбарлав.

Асуулт 1:

2022 онд Мандал Даатгал ХК зах зээлээс хувьцаагаа буцаан худалдан авах замаар хувьцаагаа халааслах уу?

Хариулт ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг:

Мандал Даатгал ХК-ны хувьцааны бодит ханш Мандал Даатгал ХК-ны ашиг орлоготой дүйцэхүйц зах зээлийн ханш байх ёстой гэсэн бодлогыг баримталдаг. Өнөөдрийн байдлаар Мандал Даатгал ХК-ны ханш 100 гаран төгрөг байгаа. Энэ ханш нь манай байгууллагын бодит ханш гэж харж байгаа. Цаашаа манай ханш өсөх потенциал байгаа гэж үзэж байгаа учир нь манай байгууллагын ашиг орлого нэмэгдэж, энэ зохион байгуулж байгаа форумуудаар дамжуулан борлуулалтыг нэмэгдүүлэх стратеги барьж байгаа.

ТУЗ-ийн зүгээс хувьцааны ханшийг зориудаар өсгөх эсвэл зориудаар буулгах сонирхол байхгүй, Хувьцаа халааслахын хувьд Мандал Даатгал ХК нь ТУЗ-өөс шийдвэрлэсэн дүн буюу 200 сая орчим төгрөгийн хувьцааг зах зээлээс худалдан аваад ажилчдадаа эзэмшүүлж байсан түүхтэй. Энэ жилийн хувьд Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч хүний нөөцийн бодлогын хүрээнд 100-200 сая төгрөгийн хувьцааг худалдан авахаар ТУЗ-д оруулж танилцуулсан тохиолдолд бид хувьцааг халааслахыг үгүйсгэхгүй. Бусдаар бол Мандал Даатгал ХК-ны ТУЗ нь хувьцааг халааслах бодол байхгүй байгаа.

Асуулт 2:

Хувьцаа эзэмшигч нь даатгал хийлгэвэл хөнгөлөлт урамшуулал авах боломжтой юу?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Батзул:

Хувьцаа эзэмшигч нар маань хэрэв даатгуулбал хөнгөлөлт авах боломж байгаа. Ямар даатгалаар болон ямар эрсдэлийг даатгуулж байгаагаас хамаарч хөнгөлөлт нь өөр байна.

Хариулт ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг: Мандал Даатгал ХК-ны бизнес төлөвлөгөөг 2004 онд Warren Buffett-ын модель дээр суурилж бичиж байсан. Warren Buffett -ын хувьцаа эзэмшигчдийн хурал нь борлуулалтын хурал болж дуусдаг. Бүх хувьцаа эзэмшигчдээ борлуулалт хийдэг. Тиймээс бид та бүхний мэдээллийг аваад эргээд та бүхэнд хөнгөлөлттэй, урамшуулалтай даатгалын бүтээгдэхүүнийг та бүхэнд санал болгоно. Харин та бүхэн өөрийн хувьцаа эзэмшиж байгаа компаниараа даатгуулаарай гэж уриалмаар байна.

Асуулт 3:

Б.Жавхлан захирал яагаад ажлаа өгч байгаа вэ? Өөр ажилд томилогдож байгаа юу?

Хариулт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Энхтүвшин:

Түрүүн хурлын явцад Б.Жавхлан захирал “Мандал Даатгал” ХК-ны Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаа хүлээлгэн өгөөд “Мандал Лайф” ХХК-ны Гүйцэтгэх захирлаар ажиллахаар болсон гэдгийг танилцуулсан тул энэ асуултад хариулсан гэж үзлээ.

Асуулт 4:

Үндсэн давхар даатгагчаа хэзээ солих гэж байгаа вэ? Геополитикийн асуудал хэрхэн нөлөөлнө гэж үзэж байгаа вэ?

Хариулт Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Т.Батзул:

Украины нөхцөл байдлаас хамаараад манай үндсэн даатгагч Russian reinsurance байдаг бид AM Best үнэлгээний компаниар энэ жилийн үнэлгээг хийлгэхэд Russian reinsurance давхар даатгалын компанийн талаар нэмэлт мэдээллийг авахыг хүссэн. Бид тус мэдээллийг аваад сая 3 сард явуулсан бөгөөд манай компанийн үнэлгээг BB+ хэвээр үлдээсэн. Бидний зүгээс давхар даатгалын компанийг энэ оны 9 сараас солих байх, гэхдээ баруун европын давхар даатгалын компаниуд дайнтай холбоотойгоор үнийн санал өгөхгүй, эсвэл өндөр үнэ өгөх магадлалтай байгаа. Гэхдээ бид азийн давхар даатгалын компаниудтай холбогдож судалгааг мөн авч байгаа.

Хариулт ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг: Бид олон давхар даатгалын компаниудтай хамтарч ажилдаг гэхдээ Russian Reinsurance манай том давхар даатгалын хамтрагч компани. ТУЗ-ийн зүгээс давхар даатгалын гэрээг сайн хийхийг бид шаарддаг. Учир нь том хэмжээний даатгалын тохиолдол болоход их хэмжээний нөхөн төлбөр төлөх эрсдэл бий болдог. Тиймээс давхар даатгалын бодлогыг бид ТУЗ дээр авч хэлэлцдэг.

САНАЛ ХУРААЛТ

Асуулт хариулт дуусаж хурлын дэгийн дагуу санал хураалт эхэлснийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зарлав.


Санал хураалт авах аргачлалын танилцуулга: Цахимаар хэрхэн санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХАД АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

“Мандал Даатгал” ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 543,782,458 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ХОЁР ЕРДИЙН ГИШҮҮНИЙГ ҮҮРЭГТ АЖЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:



Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүн Отгон овогтой Мөнхжаргалын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэрийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 539,610,869 ширхэг хувьцааны санал буюу 99 хувийн саналаар, ТУЗ-ийн ердийн гишүүн Батсайхан овогтой Жавхлангийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэрийг батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 542,400,040 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар, ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохыг батлав.

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ХОЁР ГИШҮҮНИЙГ СОНГОХ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн ТУЗ-ийн ердийн хоёр гишүүдийг сонгоход өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчд дараах байдлаар ТУЗ-ийн нэр дэвшигч гишүүдэд өгснөөр батлав. /Кумулятив аргаар санал хураасан/ Үүнд:

Ердийн гишүүнд нэр дэвшигчид	Кумулятив саналын тоо	Хувь
Гансүх овогтой ДАШДЭНДЭВ	540,096,247	49.6 %
Түмэннасан овогтой БАТЗУЛ	547,226,497	50.3 %

КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

ТУЗ-ийн 2022 үйл ажиллагааны зардлын төсөв батлахад өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 543,755,584 ширхэг хувьцааны санал буюу 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлав.

Санал хураалт дууссаныг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зарлав.

Тооллогын комиссын дарга З.Цэндсүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга “Мандал Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга хурлын хаалтыг үгийг хэлснээр 16 цаг 35 минутад хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.ЭНХТҮВШИН

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛДСАН:

Ө.ГАНЗОРИГ

Хурлын дарга